

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАНИЛЦУУЛГА ТАЙЛАН

2022.02.12
хот

Улаанбаатар

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго, үндэслэл, арга зүй

Холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийж, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, хариуцлагыг сайжруулах зорилготой.

Хяналтад авсан Монгол Улсын хууль, УИХ-ын тогтоол, УИХ-ын Байнгын хорооны тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, ҮАБЗ-ийн зөвлөмж, Засгийн газрын тогтоол, Ерөнхий Сайдын захирамж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын албан даалгаврын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.3 болон 8.1 дэх заалтыг удирдлага болгов.

Хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд буюу unelgee.gov.mn –ийн Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн цэсэд байршсан 85 шийдвэрийн 121 заалтын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн зүйл, заалтын хэрэгжилтийг үнэлэх аргачлалыг удирдлага болгон хийв.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

2021 оны жилийн эцсийн байдлаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрыг хяналтад авч, хэрэгжүүлэхийг үүрэг болгосон:

- Монгол Улсын 3 хуулийн 3 заалт;
- УИХ-ын 10 тогтоолын 18 заалт;
- УИХ-ын байнгын хорооны 5 тогтоолын 7 заалт;
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1 зарлигийн 1 заалт;
- Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 1 зөвлөмжийн 1 заалт;
- Засгийн газрын 41 тогтоолын 49 заалт;
- Ерөнхий Сайдын 2 захирамжийн 2 заалт;
- Засгийн газрын хуралдааны 21 тэмдэглэлийн 34 заалт;
- Засгийн газрын 1 албан даалгаврын 6 заалт нийт **85 шийдвэрийн 121 заалтыг** хяналтад авч хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийлээ. 2021 оны жилийн эцсийн байдлаар хэрэгжилтийн **дундаж үнэлгээ 83.8 хувь** байна.

Хяналтад авсан шийдвэрийн тоо

Засгийн газрын албан даалгавар	1	6
Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	21	34
Ерөнхий сайдын захирамж	2	2
Засгийн газрын тогтоол	41	49
Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж	1	1
Ерөнхийлөгчийн зарлиг	1	1
УИХ-ын Байнгын хорооны тогтоол	5	7
УИХ-ын тогтоол	10	18
Монгол Улсын хууль	3	3

■ Шийдвэрийн тоо ■ Заалтын тоо

Гурав. Үнэлгээний дүгнэлт

2021 оны жилийн эцсийн байдлаар хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн **83.8 хувийн хэрэгжилттэй** байна.

Үндсэн хэрэгжүүлэх нэгжээр нь харуулбал:

- Захиргаа, удирдлагын хэлтэс 4 шийдвэрийн 11 заалтын хэрэгжилт 90.0 хувь;
- Хууль эрх зүйн хэлтэс 3 шийдвэрийн 4 заалтын хэрэгжилт 90.0 хувь;
- Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс 6 шийдвэрийн 75 заалтын хэрэгжилт 81.9 хувь;
- Төрийн өмчийн бүртгэл ашиглалтын хэлтэс 4 шийдвэрийн 20 заалтын хэрэгжилт 85.3 хувь;
- Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтэс 1 шийдвэрийн 3 заалтын хэрэгжилт 100.0 хувь;
- Мэдээлэл технологийн алба 2 шийдвэрийн 8 заалтын хэрэгжилт 85.0 хувь (ТӨБАХэлтэстэй хамтран хэрэгжүүлэх 2 заалт).

2021 оны жилийн эцсийн байдлаар цаг үеийн болон нэг удаагийн шинжтэй, бүрэн хэрэгжсэн, хэрэгжилт тогтмолжсон, ТӨБЗГ-аас хэрэгжилтийг бүрэн хангасан, шийдвэртэй холбоотой дараагийн шийдвэр гарсан 41 шийдвэрийг Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим сангаас хасуулах санал хүргүүлсэн ч холбогдох хэлтсүүд дотоод хяналтандаа авч, хэрэгжилтийг ханган ажиллах.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнгээр “Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй”-ХБ 18 заалтын 5 заалт нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын чиг үүрэгт хамааралгүй тул цаашид хяналтаас хасуулах, 13 заалт нь 2021 оны эцэст гарсан шийдвэрүүд бөгөөд 2022 онд үр дүн гарч, хэрэгжилтийг тайлагнах тул “хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй” үнэлгээний төрөлд хамааруулсан болно.

Дөрөв. Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал /Зөвлөмж/

- Хэрэгжилтийг тайлагнахдаа үр дүнг хоёр мянган тэмдэгтэд багтаах, шаардлагатай тохиолдолд файлыг хавсралтаар ирүүлэх;
- Хоёроос дээш жил хяналтад байгаа шийдвэрийг тухайн тайлант оны үр дүнг өмнөх оны гарсан үр дүнгийн хамт харьцуулан тайлагнах;
- Хэрэгжилтэд хийсэн үнэлгээгээр “хэрэгжилт хангалтгүй”-30 хувь, “хэрэгжээгүй”-0 хувьтай шийдвэрүүдийг цаашид анхаарч ажиллах.

Хяналтаас хасуулах санал:

2021 оны жилийн эцсийн байдлаар нэг удаагийн шинжтэй буюу бүрэн хэрэгжсэн 28, хэрэгжилт тогтмолжсон 11, чиг үүрэгт хамааралгүй үндсэн хэрэгжүүлэгч биш 1, шийдвэртэй холбоотой агуулга ижил дараагийн тэмдэглэл гарсан 1, хамааралгүй 5, нийт 7 төрлийн 41 шийдвэрийн 46 заалтыг Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан буюу unelgee.gov.mn-ийн хяналтаас хасуулах саналыг хүргүүлж байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар чиг үүргийн хүрээнд үндсэн хэрэгжүүлэгч биш, хамааралгүй 5 заалтыг “хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй” ХБ гэж үнэлэн хяналтаас хасах саналын жагсаалтад орууллаа.

ХАСУУЛАХ САНАЛЫН ЖАГСААЛТ
(2021 оны жилийн эцсийн байдлаар)

д/д	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн нэр төрөл	Шийдвэрийн тоо	Заалтын тоо	Хэрэгжилтийн хувь	Хяналтаас хасуулах шалтгаан
1	Монгол Улсын хууль	2	2	100.0%	хэрэгжилт тогтмолжсон – 1; бүрэн хэрэгжсэн – 1.
		1	1	ХБ	үндсэн хэрэгжүүлэгч биш - 1
2	УИХ-ын тогтоол	6	10	100.0%	бүрэн хэрэгжсэн – 3; хэрэгжилт тогтмолжсон – 5; цаг үеийн шинжтэй нэг удаагийн – 2.
			1	ХБ	хамааралгүй - 1
3	УИХ-ын Байнгын хорооны тогтоол	1	1	100.0%	хэрэгжилт тогтмолжсон - 1
4	Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж	1	1	100.0%	хэрэгжилт тогтмолжсон – 1
5	Засгийн газрын тогтоол	18	16	100.0%	хэрэгжилт тогтмолжсон – 3; бүрэн хэрэгжсэн – 13;
			2	ХБ	Хэрэгжсэн, МУ-ын 2021 оны төсвийн тухай хуулийн дагуу 2022 онд үргэлжлэх төсөл арга хэмжээ байхгүй – 1; хамааралгүй – 1.
6	Ерөнхий сайдын захирамж	2	2	100.0%	бүрэн хэрэгжсэн – 2
7	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	10	9	100.0%	бүрэн хэрэгжсэн – 7; уг асуудалтай агуулга ижил дараагийн тэмдэглэл гарсан 2021.10.06-ны №54 – 1; ТӨБЗГ-аас хамаарах асуудлыг бүрэн хэрэгжүүлсэн – 1.
			1	ХБ	шийдвэрийн агуулгад хамааралгүй өөрөөр хэлбэл хязгаартад хамаарахгүй - 1
Бүгд		41	46	100.0%	100.0 хувийн хэрэгжилттэй – 41 заалт, Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй буюу ТӨБЗГазарт хамааралгүй – 5 заалт

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ДҮН (нэр төрлөөр)
(2021 оны жилийн эцсийн дүн)

2022.02.14

Улаанбаатар хот

Д/д	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн нэр төрөл	Шийдвэрийн тоо	Хэрэгжилтийг тооцсон заалтын тоо	Үүнээс:					Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй (ХБ)	Хэрэгжилтийн явцын дүн (хувиар)
				Бүрэн хэрэгжсэн (100%)	Хэрэгжих шатанд (70%)	Хэрэгжилт хангалтгүй (30%)	Хэрэгжээгүй (0%)	Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй (ХБ)		
1	Монгол Улсын хууль	3	3	2	-	-	-	1	100.0%	
2	УИХ-ын тогтоол	10	18	12	4	-	-	2	92.5%	
3	УИХ-ын Байнгын хорооны тогтоол	5	7	4	-	-	-	3	100.0%	
4	Ерөнхийлөгчийн зарлиг	1	1	-	1	-	-	-	70.0%	
5	Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж	1	1	1	-	-	-	-	100.0%	
6	Засгийн газрын тогтоол	41	49	24	14	3	1	7	82.6%	
7	Ерөнхий сайдын захирамж	2	2	2	-	-	-	-	100.0%	
8	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	21	34	13	14	3	1	3	76.5%	
9	Засгийн газрын албан даалгавар	1	6	2	2	-	-	2	85.0%	
Хэрэгжилтийн дүн (шийдвэр, заалтын тоо)		85	121	60	35	6	2	18	83.8%	

Танилцсан:

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА
Б.ЦЭНГЭЛ

А.АРИУНБОЛД

Хянасан:

ЗАХИРГАА, ХАЙРДЛАГЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА
Н.ТАНБОЛД

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН МЭРГЭЖИЛТЭН
Д.ЦЭРЭНЛХАМ